

“АНАГААХ ХАНДЛАГА” ГРУППЫН АЖЛЫН УДИРДАМЖ

Гол санаа нь:

- бид энд бусдыг сонсож,
- бие биеэ дэмжих гэж
- ямар нэгэн шүүмжлэл байхгүй,
- хэн нэгнийг засах гэсэн оролдлого байхгүй,
- зөвлөгөө өгөхгүй,
- өөрсдийгөө анагаах зорилготой ирсэн.

Хүмүүс энд ирэхдээ зовлон жаргалаа бусадтайгаа хуваалцдаг тул энд яригдах зүйлүүдийн нууцыг чандлан хадгалах нь хамгийн чухал юм.

1. хайр бол бусдыг сонсох чадвар, тиймээс бид сэтгэлээ нээж бусдыг сонсоно, бие биедээ харилцан дэмжлэг өгнө, тэгээд шүүмжгүйгээр сонсож хуваалцаж сурна.
2. бид өөрсдийгөө анагаах гэж ирсэн. Бид энд зөвлөгөө өгөх гэж эсвэл хэн нэгний үзэл бодол эсвэл зан байдлыг засах гэж ирээгүй. Бид өөрөөрөө байснаар бусдыг ч байгаагаар нь хүлээн авахад хялбар болно.
3. бид өөрсдийн тухай бусадтай хуваалцана. Өөрсдийн санааг зовоосон зүйлээ бусадтай хуваалцсанаар бид бүгд адилхан гэдгээ ойлгож бие биетэйгээ ойртон нягтрах болно.
4. бид өөрийнхөө болон бусдын онцгой шинж чанарыг хүндэлнэ; хүн бүрийн амьдрал чухал, тиймээс бид шүүмжлэх, дүгнэн цэгнэх нь утгагүй.
5. бид бие биенийхээ зөн совинг дэмжиж шилдэг хариултаа олоход нь бие биедээ туслана.
6. бидний нас, туршлага, бие биенээсээ суралцахад нөлөөгүй
7. бид бусдыг гаднах байдал, ааш зан, нөхцөл байдлаар нь тодорхойлохгүй бүхэлд нь харж сурна (бид бусдын өөрийг биш бидэнтэй адилыг нь олж харна)
8. амар амгалан - зөрчил, хайр – айдас хоёрын хооронд сонголт хийх боломж бидэнд байгааг бид үргэлж санаж явна
9. бид хуваалцсан зүйлүүдийнхээ нууцыг хадгална. Энэ нь бие биедээ итгэх итгэл, амар тайван байдлыг хангахад чухал гэдгийг бид ухамсарлана.